МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 03 өдөр Дугаар А/556 Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 01/312 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлттэй холбогдуулан Хөвсгөл аймгийн Жаргалант сум, Завхан аймгийн Их-Уул сум хоорондын хилийн цэсийн орчимд үүссэн газрын маргааныг судалж танилцуулах, санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

М.Хуягбаатар (аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:
Б.Ганзориг (аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)
Б.Эрдэнэдалай (аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)
Б.Ахмадбат (Жаргалант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга)
Ц.Бямбажав (Жаргалант сумын Засаг дарга)
Б.Пүрэвсүрэн (Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)
Ч.Содномцэрэн (Жаргалант сумын Газрын даамал)
Ө.Бадамдорж (Жаргалант сумын 1 дүгээр (Хөнжил) багийн Засаг дарга)
Б.Сайнбат (Жаргалант сумын 2 дугаар (Цэцүүх) багийн Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:
Э.Дэлгэрмөрөн (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын, Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн)

2. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үүссэн нөхцөл байдлыг судалж, авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА: П.ЛХАГВАЖАВ

Захирамж-2023

671201 1254